



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/139

Алтай хот

Салбар зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм"-ийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Г.Чинбат (аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: С.Мөнхжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Х.Баатарзориг (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Г.Оюунчимэг (Ажил олгогч эздийн холбооны дэд дарга)
Р.Санжжав ("Баян таян" ХХК-ийн захирал)
Д.Болормаа (bobo's beikery үүсгэн байгуулагч)
Л.Сумаахүү (Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)
Л.Ариунтуяа (Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч)
С.Бямбадорж (Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч)

Нарийн бичгийн дарга: Х.Энхтайван (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга)

2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дүрмийг баримтлан хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг зөвлөл (Г.Чинбат)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/139 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201000500